ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

**МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГАА**

Лагшан төв, С.Амарын гудамж, Ерөнхий сайд, 8 дугаар
хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: 26 14 89, 26 14 90, Факс: (976-11)-31 06 42
Цахим шуудан: info@monmarad.gov.mn
Цахим хуудас: www.monmarad.gov.mn

2025.12.18 № 01/525

танай ______________-ны №______________-т

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.ОЮУНТУЯА ТАНАА

Монгол Улсын Далайн захиргааны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 24 хуудастай.

ДАРГА М.ӨЛЗИЙ

9020050812
ТУЗ2198 ♀ 5292816

1425041049

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]


[illegible] : www.monmarad.gov.mn

[illegible] : info@monmarad.gov.mn ·

[illegible]: (976-51) 26 14 89 · [illegible] : (976-11) 31 06 42 ·

[illegible] 14200

[illegible] 8 [illegible]


[illegible]

9020060812

ТУ32198 & 5292816

# МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГААНЫ 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | - |
|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛТ 1. ДАЛАЙН БОЛОН УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОЖ, ОЛОН УЛСЫН СТАНДАРТАД НИЙЦҮҮЛЭН БОЛОВСРУУЛНА.** | | **ОЛОН УЛСЫН СТАНДАРТАД НИЙЦҮҮЛЭН БОЛОВСРУУЛСАН БАРИМТ БИЧГИЙН ТОО** | **0** | **1** | **I-IV УЛИРАЛ** | **92,8** |
| 1.1 | Усан замын тээврийн тухай хуулийг шинэчлэх төслийн саналыг боловсруулж Зам, тээврийн яаманд хүргүүлэх | Төслийг яаманд хүргүүлсэн эсэх Үгүй-2, Тийм-1 | 2 | I улиралд Ажлын хэсэг байгуулах<br>II улиралд Төсөл боловсруулах<br>III улиралд Санал авах<br>IV улиралд Хүргүүлсэн байна. | Хуулийн төслийн саналыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/21 дугаар тушаалаар байгуулсан.<br>Хуулийн хэрэгжилтэд хяналт тавихад тулгардаг нийтлэг хүндрэл бэрхшээл, усан замын тээврийн аюулгүй байдлыг сайжруулах зохицуулалтуудын талаар төсөлд санал авах зорилгоор 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Зам, тээврийн яамны Салбарын хяналтын газрын болон орон нутаг дахь усан замын тээврийн хяналтын улсын /ахлах/ байцаагчдыг оролцуулсан хэлэлцүүлэг байгуулсан. 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд зохион байгуулсан "Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа" сэдэвт сургалт семинарын үеэр усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн дунд хэлэлцүүлэг мөн зохион байгуулсан. Салбарын төрийн бус байгууллагуудын (Монголын завьчдын нэгдсэн холбоо, Монголын сэлүүрт завины холбоо, Монголын Рафтингийн холбоо) төлөөлөл, удирдлагуудтай уулзалтуудыг хийсэн.<br>Дээрх хэлэлцүүлэг, уулзалтын үеэр гарсан саналыг төсөлд тусгасан бөгөөд аргачлалын дагуу хуулийн төслийг боловсруулалтын ажил хийгдэж байна. | 80 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хуулийн төслийг боловсруулж 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдөр хүлээлгэн өгөх гэрээ байгуулан ажиллаж байна. | |
| 1.2. | Монгол орны зарим нуурын эрэгт байгуулсан усан замын тээврийн хяналтын пост тохижуулах | Тухайн онд хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | 0 | II улиралд Хатгалын пост тохижуулах III улиралд Ханх, Өгий нуурын пост тохижуулах | Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн "Зардал гаргах тухай" А/44 дүгээр тушаалаар Хөвсгөл аймгийн Хатгал тосгон дахь хяналтын байруудын засварт шаардлагатай зардлыг баталж, худалдан авах ажлыг зохион байгуулсан. Энэхүү засварын ажлын хүрээнд нийт 3 барилгын хана, дээвэр, шаланд дулаалга хийгдэж, доторлогоо, шалыг шинэчлэн засварласан. Түүнчлэн Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн "Зардал батлах тухай" А/72 дугаар тушаалын дагуу шаардлагатай тавилга, эд хогшлыг шинээр худалдан авах ажлыг зохион байгуулсан. Байгууллагын дотоод нөөц боломж болон батлагдсан төсвийн хүрээнд Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Ханх сум, Архангай аймгийн Өгийнуур сум дахь хяналтын 3 постыг бүрэн тохижуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. | 100 |
| 1.3. | Усан замын тээврийн салбарт шинээр нэвтрүүлэх шаардлагатай олон улсын стандартыг судлах, MNS стандарт нийцүүлэн боловсруулж, Зам, тээврийн яаманд хүргүүлэх | Олон улсын стандартад нийцүүлэн боловсруулсан MNS стандартын тоо | 0 | I улиралд Стандартыг судлах II-III улиралд Төсөл боловсруулах IV улиралд Яаманд хүргүүлэх | Стандартчиллын олон улсын байгууллага (ISO)-ын стандартуудыг судалж, Бага оврын усан замын тээврийн хэрэгсэл-Тээврийн хэрэгслийн таних тэмдэглэл-Кодчиллын систем болон Бага оврын усан замын тээврийн хэрэгсэл-Өмчлөгчийн гарын авлага гэсэн 2 стандартыг сонгон холбогдох байгууллагаар дамжуулан худалдан авсан. Уг стандартуудын орчуулгыг хийж гүйцэтгэсэн бөгөөд Үндэсний стандарт боловсруулах MNS стандартад нийцүүлэн боловсруулж, орчуулгын төслийг 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр 02/496 тоот албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. | 100 |
| 1.4 | Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, гэрчилгээ, улсын дугаар олгох журамд нэмэлт өөрчлөлт оруулах төслийн саналыг боловсруулж Зам, тээврийн яаманд хүргүүлэх | Саналыг хүргүүлсэн эсэх Үгүй-2, Тийм-1 | 2 | I улиралд Ажлын хэсэг байгуулах II улиралд Төсөл боловсруулах III улиралд Санал авах IV улиралд | Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" А/31 дүгээр тушаалаар ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр хуралдаж, журмын төсөлд санал авах ажлыг зохион байгуулсан.<br>Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан "Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа" сэдэвт сургалт, | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Яаманд хүргүүлэх | семинарын үеэр журмын төсөлд санал авах хэлэлцүүлгийг зохион байгуулсан.<br>“Монголын усчин-аврагч холбоо”, “Усан замчны толь бичиг”, “Гол, мөрөн, эргийн аюулгүй байдлыг хамгаалах холбоо”, “Монголын рафтингийн холбоо”, “Монголын завьчдын нэгдсэн холбоо” НҮТББ-д санал авах тухай албан бичиг хүргүүлж, 2 байгууллагаас санал ирүүлсэн.<br>Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн санал, танилцуулга, нөлөөллийн шинжилгээг боловсруулж, техникийн хяналтын үзлэг, оношилгооны хуудас, бүртгэлийн маягт, хувийн хэрэг зэрэг журам хэрэгжүүлэхтэй холбоотой хавсралт, төрийн бус байгууллага, иргэдээс ирүүлсэн саналыг нэгтгэн 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 01/450 тоот албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. | |
| 1.5 | Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журмын хэрэгжилтийг хангах, завь жолоодох эрхийн үнэмлэх олгох | Тухайн онд завь жолоодох эрхийн үнэмлэх олгосон тоо | 20 | I улиралд 7<br>II улиралд 14<br>III улиралд 20<br>IV улиралд 25 | “Монголын завьчдын нэгдсэн холбоо” НҮТББ-аас Архангай аймгийн Өгийнуур, Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд усан замын тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалт зохион байгуулж, нийт 93 суралцагч хамрагдсанаас 83 суралцагч чадамжтай гэж үнэлэгдсэн. 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан онолын давтан шалгалтад нийт 9 иргэнийг хамруулахад 5 нь тэнцсэн. Жилийн эцсийн байдлаар шалгалтанд тэнцсэн иргэдэд-88, нөхөж олгосон-10 нийт 98 жолоодох эрхийн үнэмлэхийг олгосон. | 100 |
| 1.6 | Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Далайн хөдөлмөрийн тухай” конвенцын хэрэгжилтийн тайланг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх | Тухайн онд хийгдсэн тайлангийн тоо | 0 | I улиралд<br>Ажлын хэсэг байгуулах<br>II улиралд<br>Тайлангийн төсөл боловсруулах<br>III улиралд<br>Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэх<br>IV улиралд | Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/42 дугаар тушаалаар Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Далайн хөдөлмөрийн тухай” конвенцын хэрэгжилтийн тайланг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.<br>Ажлын хэсэг "Далайн хөдөлмөрийн тухай" конвенцын хэрэгжилтийн тайлангийн төслийг боловсруулсан.<br>“Далайн хөдөлмөрийн тухай” конвенцын хэрэгжилтийн тайланг удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэхээр орчуулгын ажил хийгдэж байна. | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Холбогдох байгууллагад хүргүүлэх | | |
| 1.7 | “Далайн хөдөлмөрийн тухай” 2006 оны конвенцын 2022 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн орчуулгыг Зам, тээврийн яаманд хүргүүлэн нэгдэн ороход дэмжлэг үзүүлэн ажиллах | Тухайн онд хийгдсэн орчуулгын төсөл | 0 | I улиралд Төслийг боловсруулах<br>II улиралд Яаманд хүргүүлэх | Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01/105 тоот албан бичгээр Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газарт "Далайн хөдөлмөрийн тухай" 2006 оны конвенцын 2022 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн танилцуулгыг орчуулгын хамт хүргүүлсэн. | 100 |
| **ЗОРИЛТ 2. ДАЛАЙН БОЛОН УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЧАНАРЖУУЛНА.** | | **ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ ХУВЬ** | **0** | **50** | **I-IV УЛИРАЛ** | **94** |
| 2.1. | Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцонд далбааны эзэн улсын хяналт шалгалт хийх | Хяналт шалгалт хийсэн хөлөг онгоцны тоо | 21 | I улиралд 10<br>II улиралд 15<br>III улиралд 20<br>IV улиралд 25 | Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй нийт 26 хөлөг онгоцонд далбааны эзэн улсын хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн.<br>Хяналт, шалгалтын тайланг 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 02/497 тоот албан бичгээр Зам, тээврийн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн. | 100 |
| 2.2. | Далбааны эзэн улсын гэрээт хянан шалгагчийн тоог нэмэгдүүлэх | Гэрээт хянан шалгагчийн тоо | 3 | I улиралд 1<br>II улиралд 2<br>III улиралд 3<br>IV улиралд 5 | Монгол Улсын Далайн захиргаатай далбааны эзэн улсын хяналт шалгалт хэрэгжүүлэх асуудлаар хамтран ажиллах хүсэлт ирүүлсэн 5 иргэний холбогдох бичиг баримт, ажлын туршлага зэргийг судлан хамтран ажиллах гэрээ байгуулахад бэлэн болоод байна. Турк улсад Сердар Кандемир, Малайз болон Сингапур Улсад Тум Бан Ший, БНСУ-ын Бусан боомтод Сионг Сиог Лий, Турк болон Шенгений орнуудын боомтод Онур Караман, Энэтхэг болон АНЭУ-д Санжой Якоб зэрэг далайн салбарт 10-20 жил ажилласан дадлага туршлагатай мэргэжлийн боловсон хүчнийг Монгол Улсын гэрээт хянан шалгагчаар томилж хамтран ажиллах гэрээ байгуулахад бэлтгэж байна. Хамтран ажиллах гэрээний төсөл эцэслэн батлагдах асуудал хүлээгдэж байна. | 70 |
| 2.3. | Усан замын тээврийн хэрэгслийн 2025 оны техникийн хяналтын үзлэг, тооллогыг зохион байгуулах | Хяналтын үзлэг тооллогыг зохион байгуулсан эсэх Үгүй-2, Тийм-1 | 2 | III улиралд 1 | Батлагдсан хуваарийн дагуу Архангай (Өгийнуур, Тэрхийн цагаан нуур), Булган (Эгийн гол), Баян-Өлгий (Толбо нуур), Дорнод (Буйр нуур), Сэлэнгэ (Орхон-Сэлэнгийн бэлчир), Увс (Хяргас нуур), Хөвсгөл(Хөвсгөл, Тэнгис-Шишгэд бэлчир), Ховд | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | (Дөргөн, Хар ус нуур), Нийслэл (Туул-Тэрэлж гол) аймгуудад техникийн хяналтын үзлэгийг зохион байгуулсан. Үзлэгт нийт 207 усан замын тээврийн хэрэгсэл хамрагдаж, тэнцсэн-159, тэнцээгүй-6, засвартай-42, хамрагдаагүй-74 дүнтэй байна. Техникийн хяналтын үзлэгийн нэгдсэн мэдээг Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформд оруулсан. Мөн Монгол Улсын Далайн захиргаанаас 2025 оны усан замын тээврийн хөвөлтийн улирлын хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлын нэгдсэн тайланд техникийн хяналтын үзлэгийн мэдээг тусган 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр 02/490, 02/491 тоот албан бичгээр Зам, тээврийн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт болон Бодлого, төлөвлөлтийн газарт тус тус хүргүүлсэн. | |
| 2.4. | Усан замын тээврийн ажил, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх | Хяналт шалгалтын тайланг хүргүүлсэн эсэх<br>Үгүй-2, Тийм-1 | 2 | II-III улиралд Хяналт шалгалт зохион байгуулах<br>IV улиралд Тайлан хүргүүлэх | Зам, тээврийн сайдын 2025 оны А/10 дугаар тушаалаар хяналт, шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж, иргэдийн жагсаалтыг батлуулсан. Зам, тээврийн яамны Салбарын хяналтын ерөнхий байцаагчийн 2025 оны “Төлөвлөгөөт хяналт, шалгалт хийх тухай” 03/04, “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 04/04 дугаартай удирдамжийн дагуу Нийслэл, Хөвсгөл, Архангай, Булган, Сэлэнгэ, Увс, Баян-Өлгий, Ховд, Дорнод аймгуудад хяналт шалгалт хийв. Уг шалгалтад нийт 61 ААН, байгууллага, иргэн хамрагдсан. Улсын байцаагчийн акт-24, дүгнэлт-1, албан шаардлага-32, нийт 975,000 төгрөгийн торгуулийг 9 иргэнд оногдуулсан. Гүйцэтгэлийн шалгалтыг 26 аж ахуйн нэгж, иргэнд хийж, үүрэг даалгаварын биелэлт 89,2 хувьтай гэж үнэлэгдсэн.<br>Тайланг 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдөр 01/512 тоот албан бичгээр Зам, тээврийн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн. | 100 |
| 2.5. | Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах баримт бичгийн бүрдлийг хүлээн авах, шалгах, хүсэлтийг шийдвэрлэх | Тусгай зөвшөөрөл олголтын тоо | 36 | I улиралд 10<br>II улиралд 20<br>IIIулиралд 30<br>IV улиралд 40 | Тусгай зөвшөөрөл авахаар нийт 58 хүсэлтийг цахимаар хүлээн авч, хянаж шаардлага хангаагүй, буруу болон материал дутуу илгээсэн 32 хүсэлтийг буцааж, 26 хүсэлтийг Зам, тээврийн яаманд хүргүүлж, шийдвэрлүүлсэн. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛТ 3. “ХУУРАЙ БООМТЫН ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-Т ТУСГАГДСАН БАЙРШЛУУДАД ХУУРАЙ БООМТЫГ ҮЕ ШАТТАЙ БАЙГУУЛНА.** | | **ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ** | **0** | **70** | **I-IV улирал** | **100** |
| 3.1. | “Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хүрээнд Дорноговь аймгийн Замын-Үүд суман дахь “Бүс нутгийн логистикийн төв”-ийг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулах ажлыг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 0 | I улиралд 12<br>II улиралд 25<br>III улиралд 37<br>IV улиралд 50 | Дорноговь аймгийн Замын-Үүд суман дахь “Бүс нутгийн логистикийн төв (БНЛТ)-ийг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулах ажлыг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр баталсан. Төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг авч хэрэгжүүлэв. Үүнд:<br>-БНЛТ-ийн талбайг ашиглах талаар зах зээлийн тооцоо, судалгаа хийж гүйцэтгэсэн. Уг судалгааны хүрээнд БНЛТ-д 2025 оны 01 дүгээр сарын 22-23-ны өдрүүдэд “МТЗ” ТӨХК болон “УБТЗ” ХНН-ийн Замын-Үүдийн шилжүүлэн ачих ангийн дарга болон холбогдох албаны хүмүүстэй уулзалт хийсэн.<br>-БНЛТ-ийг түшиглэн авто машинаар тээвэрлэж буй импортын ачаа барааг боловсруулах, зам талбай, дэд бүтэц, барилга байгууламжийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар хуурай боомтын үйл ажиллагааг эхлүүлэх дүгнэлт, саналыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Зам, тээврийн Сайдын 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/50 дугаар тушаалаар байгуулсан ба төлөвлөгөөний хүрээнд ажлуудыг авч хэрэгжүүлэн ажлын хэсгийн дүгнэлт, саналыг боловсруулан 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 01/189 дүгээр албан бичгээр Зам, тээврийн сайдад хүргүүлсэн. Санал дүгнэлтэд үндэслэн үйл ажиллагааг эхлүүлэх талаар холбогдох шийдвэр гаргуулахаар “Чиглэл өгөх тухай” албан бичгийн төслийг боловсруулан уг бичгийн хавсралтаар хүргүүлсэн болно.<br>Мөн БНХАУ-д 2025 оны 09 дүгээр сарын 11-18-ны өдрүүдэд ажиллаж ТЭЗҮ, хөрөнгө оруулалтын тал дээр хамтарч ажиллах боломжийг танилцуулан урьдчилсан байдлаар санал солилцож ажиллав.<br>-“Дорноговь аймгийн Замын-Үүд суман дахь Бүс нутгийн логистикийн төвийг түшиглэн олон улсын | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | чанартай хуурай боомт байгуулах ажлыг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-нд нийт 10 ажил тусгагдсан бөгөөд хэрэгжилт 100%-тай. | |
| 3.2. | Монгол Улсын Засгийн газраас өгсөн олон улсын хуурай боомт байгуулах чиглэлээр эрчимтэй ажиллах чиг үүргийн дагуу Монгол Улсад олон улсын хуурай боомт байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын асуудлыг судалж гадаад улс орнуудын дэмжлэг авч төр хувийн хэвшлийн түншлэлийг хангах үүрэг бүхий Ерөнхий сайдын 2023 оны 111 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажиллах | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 30 | I улиралд 40<br>II улиралд 50<br>III улиралд 60<br>IV улиралд 80 | Ажлын хэсгийн батлагдсан төлөвлөгөөний биелэлтэд үнэлгээ хийж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 111 дүгээр захирамжийн хүрээнд МУ-ын Далайн захиргааны гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр баталж, төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>-Хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр "Хуурай боомтын үндэсний стандарт" боловсруулах ажлын хэсгийг 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/47 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд БНХАУ, Сингапур Улс, БНСУ-ын холбогдох хууль, стандартуудыг орчуулан судалж, үндэсний стандартын төслийг боловсруулсан. Зам, тээврийн яаманд тус стандартыг батлуулах ажилд дэмжлэг үзүүлэх холбогдох эрх бүхий байгууллагын төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг байгуулах талаарх саналыг Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газарт танилцуулсан.<br>-Хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх хүрээнд Дэлхийн банкны санхүүжилтээр "Замын-Үүд хуурай боомтын ТЭЗҮ боловсруулах тухай" хурал Зам, тээврийн яаманд 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулагдсан ба холбогдох танилцуулгыг хийв.<br>-Хуурай боомт байгуулах газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр Дорноговь аймаг, Говьсүмбэр аймаг болон "Хүннү смарт хот"-ын холбогдох албаны хүмүүстэй уулзаж, хамтран ажилласан.<br>НҮБ-ын АНДНЭЗК-ийн 2 жилд нэг удаа болдог Ажлын хэсгийн VI хуралдаанд 2025 оны 11 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд төлөөлөл оролцож, МУ-ын Засгийн газрын тогтоолоор Хуурай боомт байгуулахаар батлагдсан "Чойр" байршлыг Монгол Улсын хуурай боомтын жагсаалтад албан ёсоор оруулах тухай нэмэлт өөрчлөлтийн төслийг батлуулсан.<br>Түүнчлэн боломжит хуурай боомт байгуулах зорилгоор хашилтад тэмдэглүүлсэн Чойбалсан хуурай боомтын байршлыг хашилтаас гаргаж тэмдэглүүлснээр Монгол | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Улс нийт 9 хуурай боомттой байхаар ОУ-ын хэмжээнд баталгаажуулав.<br>“Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 111 дүгээр захирамжийн хүрээнд Монгол Улсын Далайн захиргааны хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө”-нд нийт 24 ажил тусгагдсан бөгөөд хэрэгжилт 81.6%-тай байна. | |
| 3.3. | Буйр нуурт усан замын боомт байгуулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллах | Ажлын хэсгийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хувь | 0 | I улиралд 12<br>II улиралд 25<br>III улиралд 37<br>IV улиралд 50 | Зам, тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Улирлын чанартай Буйр нуур усан замын боомт байгуулах тухай” А/259 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, төлөвлөгөө батлан холбогдох ажлуудыг хэрэгжүүлэн ажилласан. Ажлын хэсгээс нэгдсэн санал, дүгнэлтийг боловсруулан 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 01/190 тоот албан бичгээр Зам, тээврийн сайдад хүргүүлсэн.<br>Мөн Хилийн боомтын захиргааны 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01/09 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу “Буйр нуур усан замын улирлын чанартай боомт байгуулах ТЭЗҮ боловсруулах ажлын даалгавар”-т холбогдох санал өгөх, үнэлгээний хороонд орж ажиллах ажилтнуудын мэдээллийг 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01/09 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн болно. | 100 |
| 3.4. | “Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хүрээнд Замын-Үүд, Улаанбаатар байршлуудад эхлэл цэг болох далайн боомтуудтай харилцаа тогтоож, хамтын ажиллагааг бэхжүүлэх | Хамтын ажиллагааг эхлүүлж чадсан эсэх Үгүй-2, Тийм-1 | 2 | I-II улиралд Харилцаа тогтоох боомтуудыг жагсаалтаар гаргах<br>III-IV улиралд Уулзалт зохион байгуулах | Замын-Үүд, Улаанбаатар байршлуудад эхлэл цэг болох далайн боомтуудтай харилцаа холбоо тогтоох зорилгоор БНХАУ-ын далайн боомтуудын үнэлгээ хийж, холбогдох ажлуудыг төлөвлөв.<br>БНХАУ-ын Шаньдун мужийн Рижао далайн боомттой хамтран ажиллах, судалгаа хийх зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 13-16-ны өдрүүдэд тус боомтод уулзалт зохион байгуулж, санал солилцсон.<br>БНХАУ-ын судлаач Др.Би Делитэй Монгол Улсын зүүн босоо тээврийн коридорын дагуу хуурай боомтын холболтын тал дээр хамтарч ажиллахаар 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр уулзалт хийж, санал солилцсон.<br>БНХАУ-ын Бээжин, Шанхай хот болон Тяньжин далайн боомтуудтай хуурай боомтын холбогдох төслүүдийг танилцуулах цаашид хамтарч ажиллах, санал солилцох зорилгоор 2025 оны 09 дугаар сарын 11-18- | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ны өдрүүдэд ажиллаж эдгээр боомтуудтай холбоо тогтоон ажиллаж байна: Үүнд:<br>-Тяньжин далайн боомтын холбогдох байгууллагуудтай хуурай боомтын төслийн талаар танилцуулах уулзалт;<br>-“Шанхай олон улсын боомт групп”-ийн Шандун чингэлэг тээврийн терминалын үйл ажиллагаатай туршлага судалж, хамтарч ажиллах уулзалт;<br>-Шанхай хотын инженерийн зураг төслийн хүрээлэн (Групп) ХХК-тай хуурай боомтын төслүүдэд хамтарч ажиллах боломжийн талаар санал солилцох уулзалтыг хийсэн.<br>-Шанхай хотын инженерийн зураг төслийн хүрээлэн (Групп) ХХК-тай Олон улсын чанартай хуурай боомт хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах тухай санамж бичгийн төслийг боловсруулан Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газарт 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 01/458 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн Зам, тээврийн яамнаас ирүүлсэн саналыг тусгаж 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 01/476 тоот албан бичгээр Гадаад харилцааны яаманд уламжилж өгөхийг хүссэн. | |
| 3.5. | БНХАУ-ын Ляонин мужийн Далянь болон бусад далайн боомтуудаас ачаа тээвэрлэлтийг эхлүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллах | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 50 | I улиралд 60<br>II улиралд 70<br>III улиралд 80<br>IV улиралд 100 | 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр “Монложистик” ХХК-тай автомашиныг задгайгаар тээвэрлэх туршилтын тээврийг хамтарч гүйцэтгэх талаар ээлжит уулзалтыг зохион байгуулсан. Уг компанийн БНХАУ-ын талын хамтрагчид тус улсын гаалийн байгууллагаас шаардлагад нийцэхгүй байгаа тухай бичгийг хүлээн авснаас хойш туршилтын тээврийг үргэлжлүүлэхээс татгалзсан болно.<br>-Монгол, БНХАУ-ын хилийн боомтын менежментийн хамтын ажиллагааны комиссын VI хуралдаан Улаанбаатар хотноо 2025 оны 07 дугаар сарын 07-08-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ба тус хуралдаанаар гаалийн асуудлыг шийдвэрлүүлэхээр “Монгол Улсын гуравдагч орноос импортлогдсон автомашин болон БНХАУ-аас экспортлогдсон автомашиныг тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн Замын-Үүд-Эрээн боомтоор нэвтрүүлэх” асуудлын саналыг тусгуулан хэлэлцүүлж, цаашид төлөвлөгөө гарган холбогдох асуудлыг хоёр тал судлан | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шийдвэрлэх чиглэлээр хамтарч ажиллахаар тохиролцов.<br>-Монгол Улсын Далайн захиргаанаас 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02/494 тоот албан бичгээр БНХАУ-ын далайн боомтоос туршилтын тээвэрлэлтийг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд 2025 онд хийж гүйцэтгэсэн ажлын илтгэх хуудсыг Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.<br>"Туршилтын тээвэрлэлтийг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө"-нд нийт 8 ажил тусгагдсан бөгөөд хэрэгжилт 96%-тай. | |
| 3.6. | Олон улсын хуурай боомтын төлөвлөлт, бүтээн байгуулалтын чиглэлээр сайн туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр үе шаттай арга хэмжээ авч ажиллах | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 50 | I улирал 60<br>II улирал 70<br>IIIулирал 80<br>IV улирал 100 | БНСУ-ын Далайн хэрэг, загас агнуурын яамны урилгаар "Бидний далай 2025" олон улсын хурал Далайн захиргааны төлөөлөл оролцсон ба тус улсын "Логистикийн байгууламжийн хөгжүүлэлт, удирдлагын тухай" хуулийн талаар холбогдох судалгааг хийсэн.<br>БНХАУ, Сингапур Улс, БНСУ, Европын холбогдох стандарт, эрх зүйн орчны талаар орчуулан судалсан.<br>БНХАУ-ын Шаньдун мужийн Рижао далайн боомтод 2025 оны 05 дугаар сарын 13-16-ны өдрүүдэд тус боомтод ажиллаж туршлага судалсан.<br>НҮБ-ын АНДЭЗНК-аас Хойд, Төв Азийн дэд бүс болон Монгол Улсад зориулан зохион байгуулсан "Хуурай боомтууд болон тэдгээрийг олон төрлийн тээврийн сүлжээнд нэгтгэх цахим хэрэгслүүдийн хөгжүүлэлт" сэдэвт семинарт 2025 оны 06 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд цахимаар хамрагдсан.<br>ӨМӨЗО-ны Нийгмийн шинжлэх ухааны академитай байгуулсан Санамж бичгийн хүрээнд Монгол Улсад хийх судалгааны урьдчилсан хөтөлбөрийг боловсруулан санал солилцох уулзалтыг 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж, цаашид хамтран ажиллах талаар санал солилцсон.<br>Мөн БНХАУ-ын Шанхай хотод байрлах Дэлхийн яаралтай аврах байгууллагын сургалтад (WERO) 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр хамрагдсан.<br>Гадаад харилцааны яам болон НҮБ-ын Нэн буурай хөгжилтэй, Далайд гарцгүй хөгжиж буй болон Арлын жижиг орнуудын асуудал эрхэлсэн Дээд төлөөлөгчийн газар (UN-OHRLLS) хамтран зохион байгуулж буй | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Далайд гарцгүй хөгжиж буй улс орнуудын олон улсын худалдаа ба тээврийн бодлого боловсруулах” сэдэвт үндэсний сургалтад 2025 оны 12 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд 2 төлөөлөгч оролцсон болно.<br>“Хуурай боомт болон далайн боомтын холболтын чиглэлээр байгуулсан санамж бичгийн хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-нд нийт 4 ажил тусгагдсан бөгөөд хэрэгжилт 85%-тай.<br>“2025 оны сургалтын төлөвлөгөө”-нд нийт 6 ажил тусгагдсан бөгөөд хэрэгжилт 100%-тай байна. | |
| 3.7 | Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэгтгэн зохион байгуулах, далайн боомт хүргэх нөхцөл боломжийг бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллах | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 0 | I улирлал Ажлын хэсэг байгуулах<br>II улирлал Төлөвлөгөө боловсруулах<br>III улирлал Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний 25 хувийг хэрэгжүүлэх<br>IV улирлал Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний 50 хувийг хэрэгжүүлэх | Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар Чойр хуурай боомт байгуулах тухай 234 дүгээр тогтоол батлагдсан. Уг тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Чойр” хуурай боомтыг шинээр байгуулах замаар уул уурхайн бүтээгдэхүүний зангилаа бүс байгуулах ажлын хэсгийг Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын төлөөллийг оролцуулан 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/69 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр батлуулж, Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын холбогдох ажилтнуудтай 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр уулзалт зохион байгуулж дараах ажлыг авч хэрэгжүүлэв. Үүнд:<br>-Ажлын хэсгийн гишүүд Чойр хуурай боомтыг байгуулах боломжит 3 байршилтай газар дээр нь танилцаж, хуурай боомт байгуулах 500 га газрыг товлуулан газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр тохиролцов.<br>-Ажлын хэсэг хуурай боомтын хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх зорилгоор БНХАУ-д 2025 оны 09 дүгээр сарын 11-18-ны өдрүүдэд ажиллав.<br>Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүнийг БНХАУ-ын Эрээн, Ганц мод боомтоос төмөр замаар дамжуулан Шандун мужийн Рижао далайн боомт хүртэл тээвэрлэх нөхцөл боломжийн судалгаа хийж гүйцэтгэн 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 01/314 дүгээр албан бичгээр Зам, тээврийн сайдад хүргүүлсэн болно.<br>Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүнийг Чойр өртөөнөөс төмөр замаар БНХАУ-ын Эрээн боомтоор | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дамжуулан Жинжоу далайн боомт хүртэл тээвэрлэх нөхцөл, боломжийн судалгааг хийж гүйцэтгэн 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 01/504 тоот албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. Төлөвлөгөөний биелэлт 100%-тай байна. | |
| **ЗОРИЛТ 4. ХОЁР БОЛОН ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЖ, ОЛОН УЛСЫН ХУРАЛ САНААЧЛАН ЗОХИОН БАЙГУУЛАХ** | | **ХУРАЛД ОРОЛЦОГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН** | **0** | **5** | **I-IV УЛИРАЛ** | **100** |
| 4.1. | Далайн салбарын байгууллагуудтай байгуулсан хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын Санамж бичгүүдийн дагуу хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэх | Санамж бичгийн тоо<br><br>Хөгжүүлсэн арга хэмжээний тоо | 2<br><br>0 | I-IV улиралд 4<br><br>I-IV улиралд 2 | -Бүгд Найрамдах Солонгос Улсын Хөлөг Онгоц Эзэмшигчдийн холбоотой хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан.<br>-Бүгд Найрамдах Солонгос Улсын Бусан хотын Боомтын захиргаатай Далайн салбарт хамтран ажиллах Санамж бичгийг 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан.<br>-Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Далайн захиргаатай 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр санамж бичгийн хэрэгжилтийн төлөвлөгөөг баталж гарын үсэг зурсан.<br>-БНХАУ-ын Шанхай хотноо байрлах Дэлхийн яаралтай аврах байгууллагатай 2024 онд байгуулсан Санамж бичгийн хүрээнд 2025 оны 09 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд Шанхай хотод Хуурай боомтын төслийн талаарх танилцуулах уулзалт хийсэн. | 100 |
| 4.2. | Бусад улсын далайн салбарын эрх бүхий байгууллагуудтай холбоо тогтоож, хамтын ажиллагааг эхлүүлэх | Тухайн онд холбоо тогтоосон улс /байгууллага/-ын тоо | 0 | 3 | Монгол Улсын нэрийн өмнөөс хөлөг онгоцны техникийн үзлэг, шалгалт явуулдаг, техникийн гэрчилгээ олгодог хүлээн зөвшөөрдөгдсөн байгууллагуудаас олгосон техникийн гэрчилгээ болон холбогдох тайланд дүн шинжилгээ хийж тайлан боловсруулан Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газарт 12 дугаар сарын 12-ны өдрийн 01/515 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>БНХАУ-ын Шанхай хотноо байрлах Дэлхийн яаралтай аврах байгууллагатай 2024 онд байгуулсан Санамж бичгийн хүрээнд 2025 оны 09-р сарын 15-17-ны өдрүүдэд Шанхай хотод Хуурай боомтын төслийн талаарх танилцуулах уулзалт болон сургалтад оролцов. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Либер улсын Далайн байгууллагатай хөлөг онгоцны бүртгэлийн туршлага солилцох, хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах боломжийн талаар санал солилцсон.<br>-Канад улсын төлөөлөгч болох Joanna Manger-тэй дотоодын усан замын тээврийн хяналт шалгалт, аюулгүй ажиллагааны тогтолцооны талаар туршлага солилцох хамтын ажиллагааны гэрээ хийх талаар,<br>-Дани улсын төлөөлөгч Sandra Christensen Trebbien-тэй уулзаж Дани улсын Далайн яамнаас Монгол Улсад онлайн сургалт байгуулж e-certificate олгох боломжтой талаар,<br>-Панамын Далайн захиргааны төлөөлөлтэй уулзаж хөлөг онгоцны бүртгэл, далайчны гэрчилгээ (STCW), хяналт шалгалтын чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан хүлээн зөвшөөрөх баримт бичиг байгуулах боломжийг хэлэлцлээ. Нийт далайн салбарын 4 улсын холбогдох байгууллагатай харилцаа холбоо тогтоож хамтын ажиллагаа эхлүүлэхээр тохиролцлоо. | |
| 4.3. | Ажилтнуудыг салбарын олон улсын хурал, зөвлөгөөнд хамруулах | Тухайн онд оролцсон тоо | 0 | I улиралд 1<br>II улиралд 3<br>III улиралд 5<br>IV улиралд 7 | -Ази, номхон далайн бүс нутгийн далайн аюулгүй байдлын захиргааны удирдлагын 24 дэх удаагийн хурал;<br>-Олон Улсын Далайн байгууллагын Далайн байгаль орчныг хамгаалах хорооны 83 дугаар хурал болон Хүлэмжийн хийг бууруулах асуудлаарх ажлын хэсгийн 19 дүгээр хуралдаан;<br>-БНСУ-ын Бусан хотод зохион байгуулагдсан "Бидний Далай 2025" олон улсын хурал;<br>-Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулагдсан "Далайн Долоо хоног" олон улсын семинарт;<br>-Олон улсын далайн байгууллага (IMO)-ын Ассамблейн 34 дүгээр чуулган;<br>-БНСУ-ын Далайн шинжлэх ухааны технологийн институттэй албан уулзалт хийх, Хөвсгөл нуурын усан замын тээврийн судалгаа, судалгааны усан онгоц нэвтрүүлэх төсөл дээр хамтран ажиллах ажлыг зохион байгуулах уулзалт; | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Бүгд Найрамдах Сингапур улсын Тээврийн яамны харьяа Тээврийн аюулгүй байдлын мөрдөн шалгах газар (Transport Safety Investigation Bureau)-аас зохион байгуулж байгаа Азийн 25 дахь Далайн Ослын Мөрдөн Шалгагчдын Форум;<br>-Бүгд Найрамдах Кот д'Ивуар Улсын Абижан хотод Далайн аюулгүй байдал, хориг арга хэмжээг хэрэгжүүлэх дэлхийн бага хурал;<br>-Гадаад харилцааны яам болон НҮБ-ын Нэн буурай хөгжилтэй, Далайд гарцгүй хөгжиж буй орны Дээд төлөөлөгчийн газар (UN-OHRLLS) хамтран зохион байгуулсан "Далайд гарцгүй хөгжиж буй улс орнуудын олон улсын худалдаа ба тээврийн бодлого боловсруулах" сэдэвт үндэсний сургалтад оролцсон. Нийт 9 удаагийн салбарын олон улсын хурал, зөвлөгөөнд ажилтнуудаа хамрууллаа. | |
| 4.4. | Салбарын бодлого, шийдвэр, үйл ажиллагаа, үр дүнг мэдээллийн олон сувгийг ашиглан олон нийтэд сурталчлан таниулах | Тухайн онд олон нийтэд түгээсэн мэдээ, мэдээллийн тоо | 0 | I улиралд 7<br>II улиралд 15<br>III улиралд 20<br>VI улиралд 30 | Байгууллагын цахим хуудсаар салбарт хэрэгжүүлж байгаа ажил 18 удаа, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл 58 удаа болон бусад мэдээ, мэдээлэл давхардсан тоогоор 197 удаа олон нийтэд хүргэсэн байна. | 100 |
| **ЗОРИЛТ 5. МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАНА.** | | **БИЕ ДААСАН БАЙДЛЫН ДУНДАЖ ТҮВШИН** | **0** | **5** | **I-IV УЛИРАЛ** | **100** |
| 5.1. | Батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалтыг төлөвлөлттэй уялдуулах; | Тухайн онд төлөвлөлттэй уялдуулсан төсвийн хэрэгжилтийн хувь | 0 | I улиралд 25<br>II улиралд 50<br>III улиралд 75<br>IV улиралд 90 | Монгол Улсын Далайн захиргааны 3 дугаар улирлын төлөвлөгөөний гүйцэтгэл 66.7%-тай байгаа бөгөөд цалин хөлс болон нэмэгдэл суутгал 85%-тай, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 132.6%-тай, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 100.1%, хангамж, бараа материалын зардал 78.9%, эд хогшил, урсгал засварын зардал 80.73%, томилолт, зочны зардал 76.51%, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 36.83%, бараа үйлчилгээний бусад зардал 86.12%, урсгал шилжүүлэг 53.74%, хөрөнгө оруулалтын мөнгөн зардал 72.28% гүйцэтгэлтэй байна. 3-р улиралд хөрөнгө оруулалтын мөнгөн зардалд дотоод эх үүсвэрээр санхүүжих Усан замын тээврийн хяналтын зөөврийн пост, гадна хашаа, худаг зэрэг тендерийн ажил амжилттай зарлагдан хүлээн аваад байна. Мөн орлогын нийт гүйцэтгэл 87%- | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тай байгаа бөгөөд үндсэн үйл ажиллагааны орлого 90%-тай байна. 2025 оны жилийн эцсийн тайлан хараахан гараагүй байна. | |
| 5.2. | Ажилтан, албан хаагч нарыг амь нас, эрүүл мэндийн даатгалын тохиолдлын тоог нэмэгдүүлэх; | Тохиолдлын тоо | 34 | IV улиралд 36 | Тус ажлын хүрээнд “Ард даатгал” ХК-тай байгуулсан гэрээний дагуу 2025 оны 5 дугаар сард “Ай Ти лаборатори” эмнэлэгт байгууллагын нийт 40 ажилтныг урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулсан. Эрүүл мэндийн үзлэгт бүх ажилтнууд 100% хамрагдсан. | 100 |
| 5.3. | Байгууллагын тайлан, мэдээ, судалгааны чанарыг сайжруулж цахимжуулах | Тайлан, мэдээний чанарын түвшин /1-9 оноо/ | 0 | I улиралд 1.5<br>II улиралд 2.5<br>III улиралд 3.5<br>IV улиралд 4.5 | Ablesoft системийн ашиглалтыг сайжруулан, архив, бичиг хэргийг цахимжуулан ажиллаж байна. Байгууллагын үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр бичмэл хэлбэрээр тайлагнаж цахим хуудсанд байршуулсан. “Нэрийн ном” хэрэгжүүлэх жагсаалт гарган жагсаалтын дагуу байгууллагын албан бланк хэвлэмэл хуудасны өнгө, загварыг сайжруулан албан хэрэгт ашиглаж байна. Ирсэн, явсан албан бичгийг 100% цахимжсан. 26 ажилтнуудаас Googleforms ашиглан авсан судалгаагаар 7.0 оноогоор дүгнэгдлээ. | 100 |
| 5.4. | Ажлын байр, хуралдааны танхимын технологийг сайжруулах, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх; | Танхим, тоног төхөөрөмжийн хэрэгцээнд нийцсэн байдлын түвшин /1-9 оноо/ | 0 | I улиралд 2<br>II улиралд 3<br>III улиралд 4<br>IV улиралд 5 | Монгол Улсын Далайн захиргааны ажилтан, албан хаагчдын дунд явуулсан ажилтнуудын өгсөн дундаж үнэлгээ 7.34 оноо /26 ажилтан/ | 100 |
| 5.5. | Хууль тогтоомж, судалгаа, гарын авлага, холбогдох мэдээллээр хангах ажлыг цахимжуулах; | Холбогдох мэдээллийн талаарх ажилтан, албан хаагчдын үнэлгээний дундаж (хувь) | 0 | I улиралд 20<br>II улиралд 30<br>III улиралд 40<br>IV улиралд 50 | Нийт ажилтнуудын 68% энэхүү судалгаанд хамрагдсан. Үнэлгээний дундаж 80%. | 100 |
| 5.6. | Иргэд, төрийн байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг зохих журмын дагуу хүлээн авч шийдвэрлэх; | Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа /хоногоор/ | 30 | I улиралд 28<br>II улиралд 27<br>III улиралд 26<br>IV улиралд 25 | Усан замын тээврийн хэрэгслийг шинээр бүртгүүлэх 52, шилжилт хөдөлгөөн хийлгэх 18, гэрчилгээ нөхөж авах 3, тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулах 5 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч журмын дагуу тус тус шийдвэрлэсэн. 2025 оны байдлаар 100 өргөдөл ирсэн. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 100 хувьтай. Өргөдлийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног. | 100 |
| | “Нэрийн ном”-ыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх | ”Нэрийн ном”-ын нэвтрүүлэлтийн хувь | 0 | I улиралд 20<br>II улиралд 30<br>III улиралд 40 | Монгол Улсын Далайн захиргааны даргын 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/192 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, хэрэгжүүлэх ажлын | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5.7. | | | | IV улиралд 50 | төлөвлөгөөг боловсруулан, шаардлагатай судалгааг хийж гүйцэтгэсэн.<br>Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/20 дугаар тушаалаар байгууллагын “Нэрийн ном”-ын жагсаалт батлагдсан.<br>Дээрх тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр “Луна Дизайн” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, байгууллагын албан ёсны “Нэрийн ном”-ыг боловсруулах ажлыг эхлүүлсэн. Гэрээний дагуу “Нэрийн ном”-д тусгагдсан нийт 28 ажлын холбогдох материалыг бүрэн хүлээн авч, 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр гэрээ дүгнэсэн актыг үйлдсэн. “Нэрийн ном”-ыг байгууллагын хэмжээнд хэрэглээнд бүрэн нэвтрүүлсэн. | |
| 5.8. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах | Төлөвлөгөө боловсруулж батлуулсан эсэх Үгүй-2, Тийм-1<br><br>Тайлан гаргаж хугацаанд нь хүргүүлсэн эсэх Үгүй-2, Тийм-1 | 2 | Тухайн жилд-1 | Байгууллагын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 1/40 тоот албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. Уг төлөвлөгөөг (www.tender.gov.mn) цахимаар илгээн батлуулсан. Төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг үнэлгээний хороо байгуулан тендерийг зохион байгуулсан. Төлөвлөгөөнд 20 арга хэмжээ тусгаснаас бүх арга хэмжээг амжилттай зохион байгуулсан. Тайланг Зам, тээврийн яаманд 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 01/510 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 100 |
| 5.9. | Монгол Улсын нэгдэн орсон далайн салбарын олон улсын байгууллагын төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулах | Төлбөрийг хугацаанд нь гүйцэтгэсэн эсэх Үгүй-2, Тийм-1 | 2 | III улиралд 1 | Алсын зайнаас байршил тогтоох ОУ-ын үйлчилгээний төлбөрт 6,473,833.13 төгрөг, Хөлөг онгоц хяналтын системийн жилийн төлбөр 21,206,880.00 төгрөг, Хиймэл дагуулын системийн үйлчилгээний төлбөр 49,699,864.16 төгрөг, хөлөг онгоцны ахисан түвшний шинжээч сургах сургалтад 6,549,150.72 төгрөг, Далбааны эзэн улсын хяналт шалгалт /гэрээт инспектор/ 2,572,584.96 төгрөг. Нийт 86,502,312.97 төгрөгийн төлбөр төлсөн. Олон улсын далайн байгууллага, Олон улсын далайн ёроолын байгуулага зэрэг гэрээ конвенцийн хүрээнд гишүүнээр нэгдэн орсон олон улсын байгууллагуудын нэмэмжлэх хараахан ирээгүй байгаа тул төлөвлөгөөнд тусгагдсан зардал бүрэн төлөгдөөгүй байна. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5.10 | Үндэсний аудитын газар болон бусад хяналт шалгалтаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах | Хэрэгжилтийн хувь | 0 | IV улиралд 80 | 2024 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газрын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 07/1278 тоот албан бичгээр хязгаарлалттай дүгнэлт ирүүлсэний дагуу 13 зөвлөмж, албан шаардлага ирүүлсэн. Актын хүрээнд зөрчил дутагдлыг арилгуулан биелэлтийг заасан хугацаанд 2025 оны 08 дугаар сарын 28-ны санхүүгийн тайлангийн аудитын системд бүрэн оруулж, баталгаажуулсан.<br>Үндэсний Аудитын газар 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр явцын хяналт хийж 100% хэрэгжилттэй үнэлэгдсэн. | 100 |
| 5.11 | Ёс зүй, мэдлэг чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх, сургалтууд зохион байгуулах | Хамрагдах албан хаагчдын эзлэх хувь | 0 | I улиралд 25<br>II улиралд 50<br>III улиралд 75<br>IV улиралд 100 | | 100 |
| 5.12 | Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах | Албан хаагчдын нийгмийн баталгааны талаарх дундаж үнэлгээ /1-9 оноо/ | 0 | I улиралд 1.5<br>II улиралд 2.5<br>III улиралд 3.5<br>IV улиралд 4.5 | Ажилтнуудын нийгмийн баталгаа, ажиллах нөхцлийг сайжруулахаар Монгол Улсын Далайн захиргааны даргын 16 удаагийн тушаалаар нийт 37,237,200 төгрөгийн тусламж дэмжлэг олгосон байна.<br>Судалгаанд 26 ажилтан хамрагдсан ба нийгмийн баталгааны хөтөлбөрийн дундаж үнэлгээ 7,11 оноогоор үнэлэгдсэн байна. | 100 |
| 5.13 | Байгууллагын тайлан, танилцуулгын агуулга, загварыг сайжруулж нийтлэх | Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин /1-9 оноо/ | 0 | I улиралд 2<br>II улиралд 3<br>III улиралд 4<br>IV улиралд 5 | Судалгаанд 26 хэрэглэгч хамрагдсан ба дундаж үнэлгээ 7,1 оноогоор үнэлэгдсэн.<br>Байгууллагын тайлан мэдээг monmarad.gov.mn сайтад тухай бүрд нь нийтэлж байгаа бөгөөд оруулсан мэдээ, тайланд ирүүлсэн гомдол саналгүй байна. Судалгааг Googleforms ашиглан Monmarad.gov.mn байгууллагын вэб хуудсанд иргэдээс нээлттэй сэтгэл ханамжийн судалгаа явуулсан. | 100 |
| **ЗОРИЛТ 6. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ САЙЖРУУЛНА.** | | **БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ТАЛААРХ ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ** | **0** | **60** | **I-IV УЛИРАЛ** | **100** |
| | Байгууллагын байнга хадгалах архивын баримтыг цахимжуулах, цахим санг | Цахимжуулалтын хувь | 0 | I улиралд 20<br>II улиралд 30<br>III улиралд 40 | Үндэсний төв архивын хөмрөгт Байнгын хадгаламжийн нэгж хүлээлгэн өгөх ажлын хүрээнд 2007-2024 оны баримт материалаа цэгцлэн ангилах ажил үргэлжилж | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6.1. | баяжуулах, тэдгээрт тавих шаардлагыг хангуулах | | | IV улиралд 50 | байна. 2007-2024 оны баримт одоогийн байдлаар байнга хадгалах хадгаламжийн нэгж 183, 70 жил хадгалах хадгаламжийн нэгж 34, түр хадгалах хадгаламжийн нэгж 180, устгах жагсаалтад 36 хадгаламжийн нэгж бүртгэгдсэн байна. Архивын баримт материал цэгцлэх ажил 80 хувийн явцтай байна. | 100 |
| 6.2. | Байгууллагын сүлжээ, программ хангамжийн аюулгүй байдлын төлөвлөгөө гаргаж, эрсдэлийн үнэлгээ хийх | Төлөвлөгөө гаргасан эсэх<br>Үгүй-2, Тийм-1<br><br>Эрсдэлийн үнэлгээний хийсэн эсэх<br>Үгүй-2, Тийм-1 | 2 | I-II улиралд 1<br><br>III-IV улиралд 1 | 2025 оны 02 дугаар сард төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Төлөвлөгөөний дагуу байгууллагын 40 ширхэг компьютерт албан ёсны эрхтэй үйлдлийн систем, хэрэглээний программ суулгасан. Мөн вирусийн хамгаалалт ба системийн аюулгүй байдал хүрээнд байгууллагын 40 ширхэг компьютерт антивирусний программ суулгаж, нийт 29 компьютерыг форматалсан. Сүлжээний хяналтыг тогтмол хийж, тайлант хугацаанд нийт 21 компьютерын сүлжээний утсыг холбосон байна. Мэдээллийн аюулгүй байдлын аудит, эрсдэлийн үнэлгээний “Кибер шилжилт” ХХК-тай гэрээ байгуулан эрсдлийн үнэлгээ хийлгэсэн. Аудитын зөвлөмжийн дагуу “Женералтеч” ХХК-иар байгууллагын дотоод сүлжээг шинэчлэн зохион байгуулсан. | 100 |
| 6.3. | Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах | Арга хэмжээний тоо | 0 | II улиралд 1 | Тагнуулын Ерөнхий газарт 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 09/1229 дугаар албан бичгийг үндэслэн Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн “Нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалт батлах тухай” А/141 дүгээр тушаал батлагдсан болно. | 100 |
| 6.4. | Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлах | Батлагдсан журмын тоо | 0 | I улиралд 1 | Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/02 дугаар тушаалаар Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн баталсан. | 100 |
| 6.5. | Тоон гарын үсгийг албан хэрэгцээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах | Тоон гарын үсэгтэй болсон ажилтны тоо | 0 | I-IV улиралд | “Монпасс” ХХК-тай гэрээ байгуулан тоон гарын үсгийн гэрчилгээг авч, ашиглалтад нэвтрүүлсэн. Нийт 25 ажилтнуудыг тоон гарын үсэгтэй болгосон. Зам, тээврийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу үйл ажиллагаанд идэвхитэй ашиглаж байгаа 4 удирдлага байна. | 100 |
| **ЗОРИЛТ 7. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД,** | | **ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ТҮВШИН /1-9 ОНОО/** | **0** | **4.5** | **I-IV УЛИРАЛ** | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ** | | | | | |
| 7.1. | Байгууллагын цахим хуудсыг хөгжүүлэх | Тухайн жилд гүйцэтгэсэн ажлын тоо | 0 | I-II улиралд 1<br>III улиралд 2<br>IV улиралд 3 | 1.Байгууллагын үндсэн цахим хуудасны загварыг (https://monmarad.gov.mn/index2) өөрчлөх ажил хийгдсэн бөгөөд зарим цэсэнд нэмэлт талбар оруулсан. Үүнд:<br>Мэдээ цэсэнд<br>- Ярилцлага, нийтлэл<br>- Статистик мэдээлэл<br>- Видео мэдээ<br>Ил тод цэсэнд<br>- Төсөв санхүү<br>2.Хөлөг онгоцны бүртгэлийн программ (shipregistry.monmarad.gov.mn)-д<br>- Баталгаажуулалт хуудсанд засвар оруулсан,<br>- Гэрчилгээнүүдэд драфт шат болон нэмэлт баталгаажуулалтын систем нэмсэн,<br>- Хөлөг онгоцны мэдээлэл солигдоход үүсэж байсан алдааг зассан,<br>- Далайчны чадамжийн гэрчилгээнүүдэд нэмэлт “Capacity” болон “Nationality” сонголтууд нэмсэн,<br>- Хөлөг онгоцны “Radio equipment” цэсэнд “Apparatus” төрөл нэмсэн.<br>- "Certificate of Non-Encumbrance" болон "Deletion Certificate" гэрчилгээний хугацаагүй байх нөхцөлийг системд шинэчлэн тохируулсан.<br>Эдгээр гэрчилгээнүүд хугацааны хязгааргүй байдлаар хүчинтэй байх боломжийг бүрдүүлсэн бөгөөд систем нь хасагдсан онгоцны мэдээлэлд холбогдох гэрчилгээг хүчинтэй байдлаар хадгалах боломжтой болсон.<br>3.Усан замын тээврийн бүртгэл мэдээллийн сангийн программ (waterway.monmarad.gov.mn)-ийн өгөгдлийн санг Үндэсний дата төвийн серверт бүрэн шилжүүлсэн. Үүний үр дүнд төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-тэй холбогдож, бусад төрийн байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцох боломжтой болсон. Мөн Усан замын тээврийн бүртгэл мэдээллийн сангийн программаас E-Mongolia-аар дамжуулан 3 төрлийн лавлагаа гаргахаар бэлтгэл ажил хангагдаж байна. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Байгууллагын цахим хуудаст өдөр тутмын үйл ажиллагаа, цаг үеийн мэдээ мэдээллийг цаг тухай бүрд нь оруулж, олон нийтэд сурталчлан ажилласан. | |
| 7.2. | Байгууллагаас зохион байгуулсан ажлын талаар хураангуй бичмэл мэдээллийг олон нийтэд хүргэх | Тухайн жилд хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн тоо /Давхардсан тоогоор/ | 0 | I улиралд 5<br>II улиралд 10<br>III улиралд 15<br>IV улиралд 20 | Байгууллагын үйл ажиллагааны болон онцлох ажлын талаар вэб хуудсанд 57 мэдээ, 7 сошиал контент, баярын өдрүүдэд мэндчилгээний 9 постер бэлтгэж ажиллалаа. Байгууллагын “Нэрийн ном”-ын нэвтрүүлэх ажлын хүрээнд байгууллагын гадна болон дотоод хаяг, ажлын үнэмлэх, усан замын анхааруулах самбар, таниулах хэвлэмэл материал, лого хэвлэл, энгэрийн тэмдэг, нэгдсэн загвартай цахим шуудангийн хаяг зэргийг стандартын дагуу боловсруулан олон нийтэд харагдахуйц байдлаар байршуулж, өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол ашиглаж байна. | 100 |
| **ЗОРИЛТ 8. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЖ, СИСТЕМ ХӨГЖҮҮЛЭХ, МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, СТАТИСТИК МЭДЭЭ ГАРГАН, ХЭРЭГЛЭГЧДИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ** | | **ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ** | **0** | **5** | **I-IV УЛИРАЛ** | **100** |
| 8.1. | Усан замын тээврийн тээвэрлэлтийн үйл ажиллагааны статистик мэдээг нэгтгэн ЗТЯ-нд хүргүүлэх | Мэдээ хүргүүлсэн эсэх<br>Үгүй-2, Тийм-1 | 2 | III-IV улиралд 1 | Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдээс тээвэрлэлтийн мэдээг авах ажлыг зохион байгуулсан.<br>Статистик мэдээг нэгтгэн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 01/475 тоот албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. | 100 |
| 8.2. | Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцны ачаа тээврийн мэдээг нэгтгэн боловсруулах | Мэдээ хүргүүлсэн эсэх<br>Үгүй-2, Тийм-1 | 2 | II-IV улиралд 1 | Хөлөг онгоцны эзэмшигч, менежер компани болон бүртгэлийн агентуудаас ирүүлсэн ачаа тээврийн мэдээг нэгтгэн боловсруулж 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 02/498 тоот албан бичгээр Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн. | 100 |
| 8.3. | Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааны мэдээг нэгтгэн боловсруулах | Мэдээ хүргүүлсэн эсэх<br>Үгүй-2, Тийм-1 | 2 | I-IV улиралд 1 | Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааны тайлан мэдээг 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газарт 02/493 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 100 |
| | Хөвсгөл нуурын эко системийг хамгаалах зорилгоор Хөвсгөл | Арга хэмжээг зохион байгуулсан эсэх | 2 | III улиралд 1 | Хөвсгөл нуурын эрэг дагуух хог хаягдлыг цэвэрлэх арга хэмжээг 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдөр орон | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8.4. | аймгийн Хатгал тосгон дахь усан замын зогсоолын орчмын хог хаягдлыг бууруулах чиглэлээр олон нийтэд сурталчилгаа хийх, эрэг дагуух хогийг цэвэрлэх нэгдсэн арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах | Үгүй-2, Тийм-1 | | | нутгийн иргэд, завьчидтай хамтран 7 дахь жилдээ Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд зохион байгууллаа. Энэ жил хог цэвэрлэх арга хэмжээг Сүхбаатар хөлөг онгоцны зогсоол орчмоос Далайн захиргааны хяналтын байр хүртэлх нуурын эрэг дагуу хийж гүйцэтгэлээ. | |
| 8.5. | Хөлөг онгоцны бүртгэлийн гэрчилгээг цахимаар олгох | Тухайн онд олгосон гэрчилгээний тоо | 0 | I улиралд 50<br>II улиралд 100<br>III улиралд150<br>IV улиралд 200 | Монгол Улсын Далайн захиргаанаас 1 хөлөг онгоц дээр дунджаар 3 төрлийн бүртгэлийн гэрчилгээ олгодог. Нэг удаагийн аяллын бүртгэлд бүртгэгдэж буй хөлөг онгоцонд хөлөг онгоцны төрөл, ангиллаас хамаарч 4-5 гэрчилгээ олгодог, зарим тохиолдолд чиргүүл хөлөг онгоц бүртгэгдэхэд бүртгэлийн 1 ширхэг гэрчилгээ олгодог. Энгийн түр бүртгэлд бүртгүүлэхэд эхний удаад мөн хөлөг онгоцны төрөл, ангилал даацаас хамаарч 4 ширхэг гэрчилгээ олгодог, түүнчлэн багийн гишүүдийн чадамжийн гэрчилгээ, даатгалын баталгаажуулалтын гэрчилгээ гэх мэт хөлөг онгоц эзэмшигчээс ирүүлсэн хүсэлтийн дагуу холбогдох бүртгэлийн гэрчилгээнүүдийг тухай бүр түргэн шуурхай олгож байна.<br>Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгүүлсэн хөлөг онгоцны нийт 2926 цахим гэрчилгээг 2025 оны жилийн эцсийн байдлаар олгосон байна. Үүнээс хөлөг онгоцны багийн гишүүдийн 1280 чадамжийн гэрчилгээ, хөлөг онгоц шинээр бүртгэсэн цахим гэрчилгээ 808, хөлөг онгоцны сунгалтын гэрчилгээ 345, бүртгэлээс хассан гэрчилгээ 57, бусад холбогдох 436 цахим гэрчилгээг тус тус олгосон. | 100 |
| **ЗОРИЛТ 9. САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БЭЛТГЭЖ, ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛААР ХАНГАХ** | | **АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН /1-9 ОНОО/** | **0** | **5** | **I-IV УЛИРАЛ** | 100 |
| 9.1. | Гадаадын их, дээд сургууль, сургалтын төвүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх, боловсон хүчнийг сургаж | Тухайн онд сургалтад хамрагдсан ажилтан, албан хаагчдын тоо | 0 | I улиралд 2<br>II улиралд 4<br>III улиралд 6<br>IV улиралд 8 | Бруней Улсад зохиогдсон Олон Улсын Далайн байгууллагын конвенцын сургалтад 2 ажилтан, Дэлхийн Далайн Их сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрт 1 ажилтан, Олон Улсын Далайн байгууллагын цахим | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллах | | | | сургалтад 2 ажилтан, Ази, Номхон далайн Нийгэм, Эдийн засгийн комиссын “Цаасгүй худалдааны тухай” цахим сургалтад 2 ажилтан, НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)-ын Олон талт тээврийн хэрэгслийн баримт бичгийн тухай семинарт 3 ажилтан, нийт 10 ажилтан тус тус хамрагдсан. | |
| 9.2. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, тайлагнах ажлыг зохион байгуулах | Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | 0 | I улиралд Төлөвлөгөө боловсруулах<br><br>II-III улиралд Сургалт зохион байгуулах<br><br>IV улиралд Тайлан хүргүүлэх | ХАБЭА-н сарын аяны хүрээнд байгууллагын хэмжээнд 5 төрөлт тэмцээнийг 2025 оны 04 дүгээр сарын 19-ний өдрөөс 20-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>-Байгууллагын нийт ажилтнуудын идэвхтэй хөдөлгөөн, бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор Баянзүрх дүүргийн усан спорт сургалтын төвтэй гэрээ байгуулан 20 хувийн хөнгөлөлттэй үнээр нийт 28 ажилтныг усан спортын сургалтад хамруулсан.<br>-ХАБЭА-н дүрэм, журам болон онцгой байдлын үед үзүүлэх анхны шатны тусламж, гамшгаас урьдчилан сэргийлэх, осолд өртөгсдөд үзүүлэх анхны тусламж зэрэг хэд хэдэн сэдвээр танхимын сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулж, нийт ажилтнуудыг хамруулсан.<br>-Төлөвлөгөөний дагуу байгууллагын нийт ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж, шаардлагатай эрүүл мэндийн зөвлөгөө, эмчилгээ үйлчилгээг авлаа.<br>-Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн “Журам батлах тухай” А/35 дугаар тушаалаар бжурмыг шинэчлэн баталсан, мөн “Албан томилолтоор ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г шинэчлэн баталж зааварчилгааны хуудсанд гарын үсэг зуруулан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Монгол Улсын Далайн захиргааны 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/155 дугаар тушаалаар ХАБЭА-н 3-р шатны үзлэг Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Ханх суман дахь хяналтын постуудад зохион байгуулж, тайланг ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад 2025 оны 12 сарын 15-ны өдрийн 01/517 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Байгууллагын ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг Зам, тээврийн | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | яамны Төрийн нарийн бичгийн даргад 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/518 тоот албан бичгээр хүргүүлсэн. | |
| **ЗОРИЛТ 10: ДАЛАЙН БОЛОН УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААР ИРГЭД, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫГ МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨГӨӨГӨӨР ХАНГАН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ АЖИЛЛАХ** | | **ЗӨВЛӨГӨӨ АВСАН ИРГЭН,АЖ АХУЙН НЭГЖИЙН СЭТГЭЛ ХАНГАМЖИЙН ТҮВШИН /1-9ОНОО/** | **0** | **4,5** | **I-IV УЛИРАЛ** | 100 |
| 10.1 | Усан замын тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгэх, гэрчилгээ, улсын дугаар олгох, шилжилт, хөдөлгөөн хийх ажлыг зохих журмын дагуу хийж гүйцэтгэх | Тухайн онд шийдвэрлэсэн хүсэлтийн тоо | 0 | I улиралд 8<br>II улиралд 15<br>III улиралд 25<br>IV улиралд 35 | Улсын бүртгэлд жилийн эцсийн байдлаар нийт 281 усан замын тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна. Усан замын тээврийн хэрэгслийг бүртгүүлэх, шилжилт хөдөлгөөн, хасалт хийлгэх, хөдөлгүүрийн өөрчлөлт бүртгүүлэх, гэрчилгээ нөхөн авах нийт 78 хүсэлт, өргөдлийг аж ахуй нэгж, иргэдээс "E-Mongolia"-гаар дамжуулан хүлээн авч шийдвэрлэсэн байна. Үүнээс усан замын тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд шинээр бүртгүүлэх 52, бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийлгэх, хөдөлгүүрийн өөрчлөлтийг бүртгүүлэх 18, бүртгэлээс хасалт хийлгэх 5, гэрчилгээ нөхөн авах 3 хүсэлт, өргөдлийг зохих журмын дагуу тус тус шийдвэрлэсэн. | 100 |
| 10.2 | "Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа" сэдэвт семинарыг зохион байгуулах | Семинарт оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин /1-9 оноо/ | 0 | III улиралд 5 | "Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа" сэдэвт семинарыг 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд зохион байгуулсан.<br>Семинарт Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Захирагчийн ажлын алба, Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, Хатгал тосгоны Цагдаагийн тасаг, "Монголын завьчдын нэгдсэн холбоо" НҮТББ, "Юбикаб" ХХК, холбогдох байгууллагын мэргэжилтнүүд болон усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжийн төлөөлөл бүхий нийт 120 гаруй хүн оролцсон.<br>Семинарын үеэр Усан замын тээврийн тухай хуулийг шинэчлэлтийн хүрээнд хэрэгжүүлж буй ажил, Зөвшөөрлийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтүүд, усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөвшөөрлийг хэрхэн авах, шийдвэрлэлтийн явцын талаарх мэдээллийг оролцогчдод өгөв.<br>Семинарын төгсгөлд Усан замын тээврийн тухай хуулийг шинэчлэх төслийн санал болон "Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар гэрчилгээ олгох журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах төслийг танилцуулж, оролцогч байгууллагуудын төлөөлөл болон тээвэр эрхлэгчдээс санал авах хэлэлцүүлэг зохион байгуулсан.<br>Семинарын хөтөлбөр тусгагдсан илтгэл мэдээллийн талаар оролцогчдоос авсан судалгаагаар сэтгэл ханамжийн түвшин дундаж үнэлгээ 8,87 оноогоор үнэлэгдсэн. | |

*Төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлсэн:* **_Төсвийн ерөнхийлөн захирагч_**

Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан .................................... /................................/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(огноо)*

*Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:*

СХШҮДАГ-ын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Оюунтуяа .................................... /................................/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(огноо)*

*Тайлагнасан:* **_Төсвийн шууд захирагч_**
Далайн захиргааны дарга М.Өлзий .................................... /2025.12.18/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(огноо)*

9020050812
ТУ32198 ☏ 5260816